



“ОМНИ АССЕТ ХОЁР ТЗК” ХХК-ИЙН 2025 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юу Эй Эф Ассет Менежмент ХХК
(Хөрөнгө итгэмжлэн удирдагч)
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/,
Олимпийн гудамж, 7/2 байр, 803 тоот
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Б.Батбаяр /"Омни Ассет Хоёр ТЗК" ХХК-ийн
ТУЗ-ийн дарга/

Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл	5

1. ХБҮЦ-ны мэдээлэл

“Омни Ассет Хоёр ТЗК” ХХК нь 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд “Омни Капитал ББСБ” ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

“Омни Ассет Хоёр ТЗК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Б.Батбаяр, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Я.Мөнхбат, ТУЗ-ийн ердийн гишүүнээр С.Нина нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК ажиллаж байна.

“Омни Ассет Хоёр ТЗК” ХХК нь 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 14.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны өрөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Омни Ассет Хоёр ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011871620
Регистрийн дугаар	7085569
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2025/06/13
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	232
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	140,000
ХБҮЦ (сая төг.)	14,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	19.2%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

“Омни Ассет Хоёр ТЗК” ХХК нь ХБҮЦ-ны төлбөрийг Хүснэгт 2-т харуулсан хуваарийн дагуу төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2025/10/01	-	677,523,287.67	14,000,000,000.00
2	2026/01/05	-	706,980,821.92	14,000,000,000.00
3	2026/04/02	-	640,701,369.86	14,000,000,000.00
4	2026/07/01	7,000,000,000	662,794,520.55	7,000,000,000.00
5	2026/10/01	-	338,761,643.84	7,000,000,000.00
6	2027/01/04	-	349,808,219.18	7,000,000,000.00
7	2027/04/01	-	320,350,684.93	7,000,000,000.00
8	2027/07/01	7,000,000,000	335,079,452.05	-
Нийт		14,000,000,000.00	4,032,000,000.00	-

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ТЗК нь зээлийн хөрөнгийн багцыг 2025 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөр тасалбар болгон худалдан авсан бөгөөд худалдан авалтын өдрөөрх болон тайлант хугацааны эцсээрх багцын шинж чанарын үзүүлэлтийг Хүснэгт №3-т харууллаа.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2025.06.29	2025.06.30	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	14,000,555,268.55	13,993,246,373.36	-0.05%
Зээлийн дундаж үлдэгдэл	25,180,854.80	25,167,709.30	-0.05%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.83%	0.83%	0.00%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	5.65%	5.65%	0.00%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	35.36%	35.36%	0.00%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	70.04%	70.01%	-0.03%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	9.50	9.49	0.00%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	41.75	41.75	0.00%
Сарын дундаж төлбөрийн дүн	1,158,226.01	1,158,226.01	0.00%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	5,696,804.87	5,696,804.87	0.00%
Зээлийн тоо /нийт/	556	556	0.00%
<i>Иргэн</i>	555	555	0.00%
<i>Хуулийн этгээд</i>	1	1	0.00%
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	21,242,300,000.00	21,242,300,000.00	0.00%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.00%	0.00%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	-	27,497,686.00*	
Зээлийн үндсэн төлбөр	-	7,308,895.19	
Хүүгийн төлбөр	-	20,177,786.64	
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	11,004.17	

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2025 оны 6 дугаар сарын эргэн төлөлт болох 27.5 сая төгрөгийг гэрээний дагуу 2025 оны 7 дугаар сарын 05-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

“Омни Ассет Хоёр ТЗК” ХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 1.04 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд ТЗК-ийн хөрөнгийн багцад зээл нэмэгдэж, хасагдсан өөрчлөлт ороогүй бөгөөд хаагдсан зээл байхгүй болно.

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Омни Ассет Хоёр ТЗК” ХХК-ийг “Омни Капитал ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Омни Капитал ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч”) байна.

2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХ-24/003 тоот шийдвэрээр Б.Батбаяр, С.Нина, Я.Мөнхбат нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн Б.Батбаярыг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 3 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 4. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2025.04.07	Тусгай зориулалтын компанийн үйл ажиллагааны журмуудыг батлах тухай	“ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам”, “Эрсдэл, сонирхлын зөрлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”, “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”, “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам” болон “Үнэт цаасны төлбөр төлөх, төлбөр цуглуулах журам”, “Татан буулгах үйл ажиллагааны журам”-ыг тус тус батлав.
		Хөрөнгийн багц худалдан авах, хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг батлах тухай	Хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг баталж, багц худалдан авахтай холбоотойгоор гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.
		ХБҮЦ гаргах, түүний нөхцөлийг тогтоох тухай	ХБҮЦ-ны ерөнхий нөхцөлийг батлав.
		Санхүүгийн тайланд аудит хийх аудиторыг сонгон батлах тухай	Аудит хийх хөндлөнгийн этгээдээр “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК-ийг сонгож, гэрээ байгуулав.
		Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай	Оролцогч талуудтай гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.
		Их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай	ХБҮЦ гаргахтай холбоотой анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулах сонирхлын зөрчилтэй болон хэмжээний хэлцлийг батлав.
		Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох тухай	Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-ийг сонгож, гэрээ байгуулав.
2	2025.04.09	ХБҮЦ-ны танилцуулга батлах тухай	ХБҮЦ-ны танилцуулгыг батлаж, СЗХ болон МХБ-д хүргүүлэв.

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
3	2025.06.13	Үнэт цаасны данс нээх тухай	ТЗК нэр дээр ҮЦТХТ-д данс нээв.